



**НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар A/01

Улаанбаатар хот

**“Эрүүл дадал-Идэвхтэй амьдрал”
хөдөлгөөн өрнүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.2, 52.1.12 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны A/35 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг.“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд дэвшүүлсэн зорилт, Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан “Нийгмийн эрүүл мэнд” (2021-2024) төслийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд биеийн тамир, спортоор хичээллэх өдөр тутмын амьдралын идэвхтэй дадал хэвшилтэй иргэн, гэр бүлийг төлөвшүүлэх, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдрыг хөгжүүлэх, ажлын байр, амралт чөлөөт цагаар хийх дасгал хөдөлгөөний талаарх мэдээллийг олон нийтэд түгээж, бүх нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор “Эрүүл дадал-Идэвхтэй амьдрал” хөдөлгөөнийг дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд өрнүүлж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг уриалсугай. Үүнд:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад:

1.1. Дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн спорт заал, гаднах спорт талбайг 7 хоногийн 1-ээс доошгүй өдөр тодорхой хугацаагаар иргэдэд нээлттэй ашиглуулах

1.2. Их дээд сургууль, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын суралцагчдад хөдөлгөөний хомсдол, хоол хүнсний зохисгүй хэрэглээний хор уршиг, биеийн тамир, спортоор хичээллэх, эрүүл зөв хооллолтын ач холбогдлын талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулах

1.3. Дүүрэг, хорооноос иргэдэд өдөр тутмын амьдралын идэвхтэй зөв дадал хэвшилтэй иргэн, гэр бүлийг төлөвшүүлэх, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, бие бялдраа хөгжүүлэх, амралт чөлөөт цагаар хийх дасгал хөдөлгөөний талаарх мэдээллийг түгээн сурталчлах ажил зохион байгуулах

1.4. Хамт олноороо ажлын байрны дасгал хөдөлгөөн хийх, биеийн

тамираар хичээллэх, зохистой хооллох, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх орчин, нөхцөл бүрдүүлэх

1.5.Ажилтан, албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг тогтмолжуулах, байгууллага дотроо илүүдэл жингүй, идэвхтэй хөдөлгөөнтэй, эрүүл чийрэг иргэн байх аян өрнүүлэх

1.6.Байгууллага, анги, хамт олноороо усан спорт, йог, фитнес, бүжиг болон бусад төрлийн спортоор хичээллэхэд дэмжлэг үзүүлэх

1.7.Байгууллагын цахим хуудсаар идэвхтэй хөдөлгөөн, зохистой хооллолт, илүүдэл жингийн хор уршиг зэрэг эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээллийг нийтлэх ажлыг тогтмолжуулах, эрүүл мэндийн зөвлөгөө мэдээллийн булан ажиллуулах

1.8.Хувийн хэвшлийн байгууллагууд нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр нийгмийн хариуцлагын хүрээнд дүүрэг, хороотойгоо хамтран ажиллаж өөрийн эзэмшлийн спорт заал, талбайгаа иргэдэд хөнгөлөлттэйгөөр ашиглуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх

2.Дүүргийн иргэд, оршин суугчдад:

2.1.Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамрагдаж халдварт болон халдварт бус өвчлөлөөс сэргийлэх, өөрийн болон гэр бүлийнхээ гишүүдийн эрүүл мэндийг дэмжих

2.2.Эрүүл гэр бүл байхын үндэс болсон идэвхтэй дасгал хөдөлгөөн, зөв зохистой хооллолтыг өдөр тутмын амьдралдаа дадал болгон хэвшүүлэх

Хоёр.Энэхүү хөдөлгөөнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож эрүүл, зөв дадлыг хэвшүүлсэн ажилтан, албан хаагчид, хамт олон, иргэн, гэр бүлийг урамшуулан дэмжих, байгууллагын цахим хуудсаар алдаршуулах, сайн туршлагыг түгээн сурталчлах, байгууллага дотроо биеийн тамир, спортын дасгалжуулагч, арга зүйч ажиллуулахыг нийт байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад уриалсугай.

ДАРГА  Б.ХУЯГБААТАР

